



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.02.28-2022.03.04

← 22-5
WAL

ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.03.07-ны байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
US30	33,236.00	-1.13%	-1.95%	-6.29%	4.49%
US500	4,271.45	-1.33%	-2.35%	-5.54%	11.77%
DOW	13596.00	-1.75%	-4.49%	-7.79%	10.56%
Европ					
GB100	6,987.00	-3.48%	-6.71%	-7.74%	5.38%
DE40	13,095.00	-4.41%	-10.11%	-13.89%	-5.93%
FR40	6,062.00	-4.97%	-10.23%	-13.52%	4.83%
IT40	22,465.00	-6.24%	-12.84%	-14.68%	-2.18%
ES35	7,721.00	-3.63%	-9.02%	-9.79%	-6.83%
Ази					
JP225	25,099.00	-3.41%	-5.40%	-8.03%	-12.70%
SHANGHAI	3,397.00	-1.48%	-1.89%	-1.62%	-0.72%
CSI 300	4,389.00	-2.38%	-4.20%	-4.76%	-13.60%
CH50	14,058.81	-2.49%	-4.58%	-6.07%	-18.51%
SENSEX	52,859.00	-2.71%	-6.01%	-8.55%	4.81%
Эрчим хүч					
Газрын тос (Crude Oil)	124.89	8.00%	30.60%	42.22%	92.18%
Газрын тос (Brent)	129.09	9.30%	31.90%	42.34%	89.36%
Байгалийн хий	5.04	0.56%	14.63%	19.63%	89.41%
Шатахуун	3.79	6.91%	29.20%	44.33%	84.93%
Нүүрс	418.75	13.18%	75.21%	77.44%	377.21%
Түүхий эд					
Алт	1,989.00	1.04%	4.26%	8.97%	18.32%
Мөнгө	25.85	0.73%	5.89%	11.57%	3.06%
Зэс	5.00	2.10%	12.52%	12.10%	21.87%
Бонд (10 жил)					
АНУ	1.69	0.0442	-0.13%	-0.27%	0.10%
Англи	1.23	0.0720	-0.23%	-0.18%	0.47%
Швейцар	0.18	0.0080	-0.14%	-0.09%	0.52%
Испани	0.97	0.0070	-0.23%	-0.10%	0.59%
Португаль	0.82	0.0500	-0.29%	-0.20%	0.52%

ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



Эх сурвалж: Business Insider

- Өнгөрсөн 7 хоногт АНУ-ын компаниудын индекс 1.9-4.50 хувиар буурч байгаа нь Украин улсад өрнөж буй дайны нөхцөл байдал таамаглаж байснаас удаж магадгүй байгаатай холбоотой. Хөрөнгө оруулагчид олон улсын эдийн засагт инфляцын шок хэр нөлөөлөх болон газрын тосны ханш цаашид өсөж болзошгүй эрсдэлүүд дээр анхаарлаа хандуулж байна.
- Японы Nikkei 225 индекс 3.15 хувь, Австрали улсын индекс 0.82 хувиар уналаа.
- Түүхий эдийн ханш хүчтэй өсөж байгаагаас газрын тосны ханш 124.89 доллар хүрсэн нь ОХУ-ын газрын тосны нийлүүлэлт дээр хориг тавьж болзошгүйтэй холбоотой байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Газрын тосны үнэ ханш

Брент газрын тосны ханш



Эх сурвалж: FactSet

Дээрх зураг нь газрын тосны ханш огцом өссөн үеүдийг үзүүлж байна.

Газрын тосны ханш өнгөрсөн 7 хоногт нэг баррель нь 124.89 долларт хүрч 2008 оноос хойших дээд цэгт хүрсэн. Энэ нь ОХУ, Украин улсын дайны нөхцөл байдал хүндэрсэн болон ОХУ-д эдийн засгийн хоригууд нэмж тавьснаар олон улсын газрын тос, байгалийн хийн нийлүүлэлтэд тодорхойгүй байдал үүсгэсэнтэй холбоотой.


Өнгөрсөн үйл явдлаас харахад газрын тосны ханшны огцом өссөн үеүд нь эдийн засгийн хямралтай их ойрхон болсон. 1990, 2000, 2008 онуудыг авч үзэхэд дэлхийн эдийн засгийн уналт болсон тэр үеүдэд газрын тосны ханш жилийн дотор 2 дахин өсөж байсан түүхтэй. Харин он гарснаар энэ жил газрын тосны ханш аль хэдий нь 70 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь бензин шатахууны үнийг өсгөснөөр бизнесүүдийн тээврийн зардлыг нэмэгдүүлэх тул инфляцыг ихээхэн өсгөх эрсдэлтэй.

Газрын тосны ханш 2011 онд 100 долларыг давсан ба энэ нь 2014 он хүртэл бууралгүй үргэлжилсэн юм. Харин энэ 4 жилийн хугацаанд S&P 500 индекс нь 62 хувийн өсөлт үзүүлсэн нь хөрөнгийн зах зээлийн өсөлт газрын тосны ханштай урвуу хамаарал харьцангуй багатайг харуулж байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Европын улсуудын ОХУ-аас байгалийн хий импортолдог хэмжээ




ОХУ-ын ДНБ-ний хэмжээ нь 1.7 их наяд доллар бөгөөд энэ нь АНУ-ын Техас мужийн үзүүлэлтээс бага тул дэлхийн нийт эдийн засагт үзүүлэх нөлөө нь харьцангуй бага юм.

АНУ-ын ОХУ-руу хийсэн экспорт тухайн улсын ДНБ-ний 0.02 хувийг, импорт 0.08 хувийг тус тус эзэлдэг.

Харин ОХУ нь Европын Холбооны газрын тосны нийт хэрэглээний 28 хувийг, байгалийн хийн 41 хувийг хангадаг байна.

Бодлогын хүү

АНУ-ын бодлогын хүү /хувиар/



Бодлогын хүүтэй холбоотой 2 чухал зүйл болж байгаа нь:

1) Дэлхий дахинд инфляцын төвшин хурдтай өсөж байгаа нь төв банкнуудыг бодлогын хүүгээ өсгөж эхлэхэд хүргэсэн. АНУ-ын Холбооны Нөөц Сан (ХНС) ч мөн адил энэ жил 3-4 удаа өсгөх магадлалтай байна.

2) ОХУ, Украины дайн дэлхий дахинд тодорхойгүй байдал үүсгэж байгаа тул эрсдэл багатай АНУ-ын засгийн газрын үнэт цаас авахад хүргэснээр үнэт цаасны өгөөжийг бууруулж ХНС-нг бодлогын хүүг өмнө шинжээчдийн таамаглаж байснаас илүү багаар өсгөх болов уу гэсэн хүлээлт үүсгэж байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл




Дээрх VIX индекс нь хөрөнгийн зах зээлийн хэлбэлзлийг харуулдаг ба 30-аас дээш гарахад хөрөнгийн зах зээлд ихээхэн уналт үзүүлдэг. 2014 оноос хойш хөрөнгийн зах зээл 5 удаа 10-аас дээш хувь унаж байсан хэдий ч 2 сарын дотор тухайн уналтаас хойш 10-аас дээш хувь өссөн түүхтэй.

Иймд өнгөрсөн 7 хоногийн уналт богино хугацаанд үргэлжилж удахгүй сэргэх магадлал өндөр юм.

АНУ-ын ажилгүйдлийн төвшин /хувиар/



АНУ-ын нэмэгдсэн ажлын байрны тоо /мянган/



АНУ-ын ажилгүйдлийн төвшин 2 сард 3.8 хувь хүрч буурсан, ажлын байр шинээр 678 мянгаар нэмэгдсэн нь эдийн засаг сэргэж байгааг илтгэж байгаа ба хөрөнгийн зах зээлийн уналтыг түр зуурын байж цаашид өсөх боломжтой болохыг бататгаж өгч байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Өнгөрсөн хугацаанд өрнөсөн хөрөнгийн зах зээл дээрх үйл явдлууд

1994 он: ХНС чанга мөнгөний бодлого явуулав.

Өнөөгийн хөрөнгийн зах зээлтэй хэрхэн холбоотой вэ?

- ХНС тухайн жил бодлогын хүүг 7 удаа өсгөсөн юм.
- Газрын тосны ханш эхний хагас жилд 49 хувь өссөн.

Тухайн үеийн хөрөнгийн зах зээлийн хариу үйлдэл:

- Хөрөнгийн зах зээл тэр жил 9 хувь унасан.
- 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж 5.6-аас 8 хувь болж өссөн.

Тухайн жилийн эцэс гэхэд юу болж өрнөсөн:

- 1994 онд хөрөнгийн зах зээл 1.4 хувь өссөн бол 1995 онд 38 хувь өссөн юм.
- Харин бондын өгөөж 6 хувиас 0.6 хувь болж буурсан.

1998 он: ОХУ улс дефолт зарлаж газрын тосны ханш унасан.

Өнөөгийн хөрөнгийн зах зээлтэй хэрхэн холбоотой вэ?

- ОХУ-ын мөнгөн тэмдэгт болон хөрөнгийн зах зээл нь хүчтэй унаж, ДНБ нь ихээр буурсан тул засгийн газар нь дефолт зарласан.
- Газрын тосны ханш тухайн үед 50 хувь унасан.

Тухайн үеийн хөрөнгийн зах зээлийн хариу үйлдэл:

- Тухайн явдал тохиохоос өмнө АНУ-ын S&P500 индекс 90 хувийн өсөлттэй байсан бол ОХУ-ын эдийн засгийн уналтаас болж 1 сарын дотор 19 хувь унасан.

Тухайн жилийн эцэс гэхэд юу болж өрнөсөн:

- 1998 онд хөрөнгийн зах зээл 29 хувь өссөн бол 1999 онд 21 хувь өссөн юм.
- Харин бондын өгөөж 8.7 хувиас -0.8 хувь болж буурсан.

2015 он: ХНС бодлогын хүүг өсгөв.

Өнөөгийн хөрөнгийн зах зээлтэй хэрхэн холбоотой вэ?

- ХНС бодлогын хүүг анх удаа 0 хувиас илүү болгон өсгөв.
- Газрын тосны ханш тухайн үед 50 хувь унасан.

Тухайн үеийн хөрөнгийн зах зээлийн хариу үйлдэл:

- Хөрөнгийн зах зээл ХНС бодлогын хүүг 0.25 хувиар өсгөхөөс хэдхэн өмнө 12 хувиар унасан.

Тухайн жилийн эцэс гэхэд юу болж өрнөсөн:

- 2015 онд хөрөнгийн зах зээл 1.4 хувь өссөн бол 2016 онд 12 хувь өсөж, 2017 онд 22 хувь өссөн нь бодлогын хүү өсөж байсан ч хөрөнгийн зах зээл өсөх боломжтойг харуулсан юм.